



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/119

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч, зай хэмжих төхөөрөмж (DVOR/DME)-ийн ээлжит шалгалтын нислэгийг гүйцэтгэх агаарын хөлөг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:
М.Байгал

Нислэгийн журам боловсруулалтын албаны
дарга

Нарийн бичгийн дарга:
Г.Хишигдэлгэр

Худалдан авах ажиллагааны тасгийн
мэргэжилтэн

Б.Цэнд-Аюуш

Агаарын навигацийн үйлчилгээний газрын
Агаарын навигацийн төлөвлөлт, бодлогын
хэрэгжилт төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Л.Бат-Оргил

Монголын Аэронавигаци, инженер техникийн
ажилтнуудын холбооны гишүүн

А.Энхцэцэг

“Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл” Төрийн бус
байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (М.Байгал)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Хишигдэлгэр)-д даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 0832